



БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ  
Э.ПҮРЭВЖАВ ТАНАА

**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,  
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82099  
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,  
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn  
Цахим хаяг: www.audit.mn

2024. 07. 31 № 230

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч иргэн Эрдэнэдалайн Пүрэвжавын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS6817-1:2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS6817-6:2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS6817-8:2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого,

0702 00826

УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.


### Дүгнэлт

Эрдэнэдалайн Пүрэвжавын Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Эрдэнэдалайн Пүрэвжавын мөрийн хөтөлбөр (..... хуудас)-ийг хавсаргав.


Хувийг: Аймгийн Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



П. ГҮНЖИДМАА

**2024-2028 ОНЫ ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД БИЕ  
ДААН НЭР ДЭВШИГЧ ЭРДЭНЭДАЛАЙН  
ПҮРЭВЖАВЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**



**2024-2028 ОНЫ ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ  
ЭРДЭНЭДАЛАЙН ПҮРЭВЖАВЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

2024.07.22

Алтай хот

Нэг. Эрүүл аюулгүй орчин  
Хоёр. Цэвэр тохилог орчин  
Гурав. Эдийн засгийн орчин  
Дөрөв. Цахим орчин

**Нэг. Эрүүл аюулгүй орчин**

- 1.1. Хүнсний бүтээгдэхүүн болон хоол үйлдвэрлэлийн чанар, аюулгүй байдлыг сайжруулна.
- 1.2. Ариутгал, халдваргүйжүүлэлтийг тогтмол хийж, орчны эрүүл ахуйн стандартыг мөрдүүлнэ.
- 1.3. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 1.4. Спорт, нийтийн биеийн тамирын арга хэмжээг нэмэгдүүлж, иргэдийн оролцоо, идэвхийг сэргээнэ.
- 1.5. Гэмт хэрэг, осол гэмтэл, гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх ажлуудыг шат дараатай зохион байгуулж, дээрх чиглэлээр иргэдийн боловсролыг дээшлүүлж, зөв дадал хэвшилтэй болгоно.

**Хоёр. Цэвэр тохилог орчин**

- 2.1. Шинэ менежмент нэвтрүүлж, хог хаягдлыг бууруулна.
- 2.2. Иргэдийн тав тухтай амьдрах боломжийг нэмэгдүүлнэ.
- 2.3. Үйлчилгээний салбарт шинэлэг соёлыг бий болгоно.
- 2.4. Ус, дулаан, цахилгаан хангамжийн эх үүсвэрийн найдвартай байдлыг сайжруулна.
- 2.5. Стандартын шаардлагыг бүрэн хангуулна.

**Гурав. Эдийн засгийн орчин**

- 3.1. Бизнесийн салбарт үйлдвэрлэгч байх зарчмыг баримталж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- 3.2. Шинээр байгуулагдаж буй үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжинэ.
- 3.3. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.
- 3.4. Ажиллах хүч, мэргэжилтэй ажилтан бэлтгэхэд анхаарна.
- 3.5. Өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.



## Дөрөв. Цахим орчин

- 4.1. Цахим шинэчлэлийг эрчимжүүлнэ.
- 4.2. Интернетийн хурдыг нэмэгдүүлнэ.
- 4.3. Төрийн үйлчилгээг шуурхай хүргэж, чирэгдлийг бууруулна.

## Тав. Хариуцлагатай байдал

- 5.1. Эрүүл мэнддээ анхаарсан эрүүл орчин
- 5.2. Байгаль орчиндоо ээлтэй эко орчин
- 5.3. Хурдан шуурхай үйлчилгээтэй цахим орчин
- 5.4. Тохижилт, стандартаар тэргүүлэгч жишиг орчин
- 5.5. Шилжин суурьшигчийг далласан найрсаг орчинг бүрдүүлнэ.

